ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АМГАЛАНБАЯР

# ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

| № | Алдаа зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | | Албан шаардлага | Зөвлөмж | | |
| 1 | Ажилтан албан хаагчдад ур чадварын нэмэгдэл хөлс олгохдоо холбогдох журмыг мөрдөөгүй байна. Тухайлбал 2024 оны 4-р сард үнэлгээний хуудас, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гараагүй байхад нэр бүхий 13 ажилтанд ур чадварын нэмэгдэл хөлс олгосон байна. | | 1 | Жилдээ | Төвийн захирлын 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалаар баталсан “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын дагуу үнэлгээний хуудас, дүгнэлтийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж захирлын тушаалаар ур чадварын нэмэгдэл олгож байна. Баримт материалыг архивлаж бэлтгэсэн. |
| 2 | ЗӨСҮТөвд ажиллаж байсан 2 ахмад настны ар гэрт буцалтгүй тусламж олгохдоо байгууллагын дотоод журамд заасан хэмжээг баримтлаагүй байна. | | 1 | Жилдээ | Эхний хагас жилийн байдлаар буцалтгүй тусламжийн 3 тушаалаар нийт 350.0 мянган төгрөгийг хөдөлмөрийн дотоод журамд зааснаар олгож ажилласан. |
| 3 | Тайлант онд 29,103.7 мянган төгрөгийн томилолтын зардал, 3,632.1 мянган төгрөгийн интернэтийн төлбөр, | 1 | | Жилдээ | 2025 оны 03 дугаар сараас эхлэн зардлын эдийн засгийн ангиллын дагуу төсвийг захиран зарцуулж байна. Жишээ нь: интернэтийн төлбөрийг шуудан холбооны зардлаас, томилолтын зардлыг дотоод албан томилолтоос гэх мэт. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2,041.5 мянган төгрөгийн хэвлэлийн зардал, 195.9 мянган төгрөгийн гаалийн зардлыг тээвэр шатахуун, мэдээлэл сурталчилгааны зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас санхүүжүүлж зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчин, зориулалт бус зарцуулсан байна. | | | | |
| 4 | Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2024 оны А/446 дугаар тушаалаар үндсэн хөрөнгө акталж, данснаас хасахаар шийдвэрлэсэн боловч өмчийн харилцааны газарт төвлөрүүлэх хөрөнгөд үнэлгээ хийгдээгүй, татан төвлөрүүлээгүй байна. | | 1 | жилдээ | 2024 онд Нийслэлийн өмчийн харилцааны газарт татан төвлөрүүлэх хөрөнгийг 2025 онд актаар хүлээлгэн өгсөн. Цаашид алдааг давтан гаргахгүй байхаар зөвлөмжийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллана. |
| 5 | Ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалтын бүртгэлийг цаг бүртгэлийн цахим системээр бүртгэж байгаа боловч сарын эцэст ажилтны ажлын цагийн бүртгэлийг системээс хэвлэн авч баримтжуулаагүй, архивлаагүй байна. /НХМаягт ЦХ-1/ | | 1 | жилдээ | 2025 оны 01 дүгээр сараас эхлэн цагийн тооцоог Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын хавсралт НХМаягт ЦХ-1 маягтаар гаргаж хэвшсэн. |
| | ЗӨСҮТөвийн дэргэдэх, Эрүүл мэндийн салбарын нөөцөд байгаа эм | | | | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/173 дугаар тушаал “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | эмнэлгийн хэрэгслийг, ашиглалтын хугацаа дуусахаас өмнө хэрхэн яаж эргэлтэд оруулах, холбогдох байгууллагуудад шилжүүлэх, актлах талаар тодорхой журам байхгүй бөгөөд 567,165.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад хугацаа дууссан байсан гэх үндэслэлээр акталж устгасан, ЗӨСҮТөвийн захирлын 2024 оны А/08 дугаар тушаалаар 37,510.9 мянган төгрөгийн хугацаа дууссан вакцин, биобэлдмэлийг акталсан мөн 1,172.6 мянган төгрөгийн хугацаа дууссан 1гр-ийн тариур агуулахад үлдэгдэлтэй байна. | 1 | | жилдээ | боловсруулах, устгах заавар шинэчлэн батлах тухай", Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А193 дугаар тушаал "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зохицуулах заавар батлах тухай" тушаалуудын дагуу тус төвөөс шинэчлэн боловсруулж байгаа журмын төсөлд хугацаа дууссан, хагарч гэмтсэн, гаж нөлөө илэрсэн, цувралд эмийг зах зээлд гаргасны дараа лабораторийн болон эмнэл зүйн туршилт судалгаагаар хүний бие махбодод сөрөг нөлөө үзүүлсэн нь нотлогдон тогтоогдож хэрэглэх боломжгүй болсон эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, эмнэлгийн зориулалттай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж акталж, устгахад манай байгууллага ЗӨСҮТ-ийн захирлын тушаалаар актлаж устгах тухай саналаа хүргүүлэн ажиллаж байна. |
| 7 | Бараа материалын түүвэр тооллогоор 5,002.1 мянган төгрөгийн үнэ бүхий хачигт энцефалитын вакцин, 4,897.9 мянган төгрөгийн үнэ бүхий галзуугийн эсрэг вакцины иммунглобулинг данс бүртгэлгүй байгааг илрүүлсэн. | 1 | | | Аудитын тооллогоор илүүдсэн 9.9 сая төгрөгийн бараа материалыг төвийн захирлын 2025 оны 06 дугаар сарын 27-ний А/45 дугаар тушаалаар орлого авч хагас жилийн санхүүгийн тайланд тусгасан. |
| 8 | ХӨСҮТөвд 2,299.4 мянган төгрөгийн, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэгт 5,192.0 мянган төгрөгийн 2 | 1 | | | Үндэсний аудитын газрын албан шаардлагаар Төвийн захирлын 2025 оны 9 сарын 1-ний өдрийн Б/133 тоот тушаалаар хариуцсан ажилтанд "Сахилгын арга хэмжээ" тооцож ажилласан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | нэр төрлийн хачигт халдварын вакциныг дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй олгосон байна. | | | | |
| 9 | Төсвийн хөрөнгөөр ОХУ-аас худалдан авсан лабораторийн эм, урвалж бодисуудын гаалийн татварт 5,154.6 мянган төгрөг, НӨАТ-ийн төлбөрт 10,824.7 мянган төгрөг төлснийг бараа материалын өртөгт шингээж бүртгээгүй, тайлант үеийн зардлаар бүртгэсэн байна. | 1 | | | ОХУ-н буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдсэн лабораторийн тоног төхөөрөмжийн өртөгт гааль болон НӨАТ-н татварт төлсөн 15,979.3 мянган төгрөгийг нэмж тусган, Эрүүл мэндийн сайдын тушаалаар орлого авч хагас жилийн санхүүгийн тайланд тусгасан. |

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ Д.БОЛОРМАА

БОЛОВСРУУЛСАН:

ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ Ц.ДАРЬСҮРЭН